

**КОНТОРЫН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ ХИЙХ
ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалтын аргаар:

Захиалагч: Дулаан Шарын гол ТӨХК
Гэрээний нэр: КОНТОРЫН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ ХИЙХ
Гэрээний дугаар: ДШГ/201902012
Байгууллагын код: ДШГ

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК
Дархан-Уул аймаг Шарын гол сум
2019 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 80’000’000 хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн ажлыг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах ажил буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Web: WWW.TENDER.GOV.MN

Нэг: УРИЛГА

Тендер зарлах хугацаа: 2019-03-14

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дулаан Шарын гол ТӨХК нь тендерт оролцогчдоос **КОНТОРЫН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ ХИЙХ** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг WWW.TENDER.GOV.MN сайт дээр тавьсан болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Үнийн саналыг 2018-03-25-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө WWW.TENDER.GOV.MN сайтад байршуулсан байна.

Тендерийн нээх хугацаа 2018-03-25 өдөр 10 цаг 30 минут

Тендерт оролцогчдод дотоодын давуу эрх тооцохгүй.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана. ААНБ-н улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, татварын тодорхойлолт
4. Тендерийн үнэ
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан

тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө угсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; 2. Санхүүгийн аудитлагдсан тайлан 2018, 2017 он 3. Сүүлийн 2 жил ашигтай ажилласан байх. 4. Үнийн санал ирүүлэхээс өмнө газар дээр ирж хийгдэх ажилтай танилсан байх шаардлагатай. 5. Ажлын талбарт ажиллах боловсон хүчний мэдээлэл 6. Борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй 7. Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн наториатаар баталгаажуулсан хуулбар 8. Татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүйг баталсан тодорхойлолт 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 10. Боловсон хүчний мэдээлэл. /диплом, үнэмлэх зэргийг наториатаар баталгаажуулсан байна./ 11. Техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийсэн эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан төсөв хавсаргана. 12. Шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, ажил гүйцэтгэх хуваарь, зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгэж хүлээлгэн өгөх талаар албан мэдэгдэл ирүүлэх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цугтамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил хийх тусгай зөвшөөрөл 2. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер орчны тохижилтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл 3. Цахилгаан хангамжийн угсралт, гадна, дотно шугам сүлжээний угсралт хийх зөвшөөрөл
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Хайрхан баг Дулаан Шарын гол ТӨХК-ний байр Н.Баттулга 99174111</p> <p>Огноо: 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Хайрхан баг Дулаан Шарын гол ТӨХК-ний байр</p> <p>Огноо: 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: КОНТОРЫН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ДШГ/201902012</p>

БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЭНХЦЭЦЭГ

КОНТОРЫН БАРИЛГЫН ӨРГӨТТӨЛИЙН
АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Хийгдэх ажлын нэр	Тоо хэмжээ
Суурийн нүх ухах /3-р зэргийн хөрсөнд/	18м ³
Баганын 3м ³ хүртлэх төмөр бетон суурь цутгах	2,52м ³
Бетон шугаман суурь цутгах	7,32м ³
Ус тусгаарлах битум 2 үе түрхэх	36,64м ²
Гадна ханын өрлөгийн ажил	14,69м ³
Дотор хана өрлөгийн ажил	89,05м ²
Шал таазанд ховил татаж шилэн хана угсрах	9,25м ²
Цонх болон цонхны тавцан суулгах ажил /давхар рамтай/	4,8м ²
Хаалга суулгах	9,66м ²
0,1 тн хүртэл жинтэй ялуу	10ш
Хаалганд цоож суулгах	5ш
Хаалга цонхны амалгаа хэсгийн шаврын ажил	14,46м ²
Тоосгон ханатай барилгын бамбайн зулавчтай модон хучилт хийх	65,19м ²
Дээврийн сараалж ба хучилтын модон хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх	65,19м ²
Шланкаар дээврийн дулаалга хийх	13,03м ³
Банзан шувуун нуруу угсрах	3,11м ³
Дээврийн хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх	3,11м ³
Галд тэсвэртэй төмөр карказтай гипсээр тааз доторлох	65,19м ²
Тоосгон ханын буулгалтын ажил	3,8м ³
Дотор ханын шаврын ажил	218,9м ²
Дотор хана эмульсэн будгаар будах	218,9м ²
Тааз эмульсэн будгаар өндөр чанартай будах	65,19м ²
Бетоны дэвсгэр үе хийх шалны тэгшилгээ ба тусгаарлалт хийх	6,51м ³
20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	65,19м ²
Паркет шал хийх	65,19м ²
Бетон хаявч хийх	1,83м ³
Гадна сайдинг өнгөлөх	335,8м ²
Довжоо цутгах	1 м ³

БОЛОВСРУУЛСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

БАТЛАВ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Контторын барилгын өргөтгөлийн ажил/

д/д	Нэр төрөл үзүүлэлт	Шаардлага
1	Материал	Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа материал нь шинэ ашиглагдаагүй. Материалд лабораторийн туршилт шинжилгээ хийгдсэн байх. MNS 5526:2005 стандартын шаардлага хангасан замаскийг сонгох, эмульс буюу будгийг MNS 5252:2003 стандартын дагуу тус тус сонгож хэрэглэнэ. Будаг нь усанд урсдаггүй тогтоц сайтай сайн чанарын солонгос будагтай дүйцэхүйц байх. Цонх нь сүүлийн үеийн газар хөдлөлтөнд тэсвэртэй бат бөх байх
2	Стандарт	Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3	Байршил	Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 1-р баг, хайрхан, задгай өөрийн байр
4	Ажил	Контторын өргөтгөл засварын ажил. - Ажлын тоо хэмжээнд заасан ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. - Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар хангаж, буулгалт, болон угсралтаас гарсан хог шороог сайтар цэвэрлэж хог хаягдлуудыг цаг тухайд нь зайлуулж байх.
5	Туршлага	Ажил гүйцэтгэгч нь 3 жилд ижил төстэй ажил дор хаяж 2-ыг гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх
6	Зөвшөөрөл	Барилгын угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх
7	Баталгаа	Ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 3 жилийн хугацаанд чанарын баталгаа шаардана
8	Урьдчилгаа	Санхүүжилтын урьдчилгаа олгохгүй


Хянасан:

Ерөнхий инженер
Техникийн тодорхойлолт гаргасан.
ЗУХ-ийн дарга
ХНСХМ

Л.Нарангэрэл

Г.Чинзориг
Д.Урангуа

Дулаан Шарынгол ХК-н өргөтгөлийн байгуулалт АЗ@М 1:75



Д.д	Өрөөний нэрс	талбай м.кв
1.	Гонх	3.26
2.	Үйлчилгээний заал	21.98
3.	Диспетчерийн өрөө	17.2
4.	Серверийн өрөө	6.01
5.	Амралтын өрөө	6.04
	Нийт	54.5

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 2.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 3. Бараа нийлүүлэх | 3.1. Техникийн тодорхойлолт дээр нэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн стандарт, шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч шаардлага тавьж, авахаас татгалзах, шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр солиулах эрхтэй |
| 4. Маргааныг шийдвэрлэх | 4.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 5. Ажлын хөтөлбөр | 5.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.
5.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежер хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 6. Зөрчил, гологдол илрүүлэх | 6.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 7. Зөрчил, гологдол арилгах | 7.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
7.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 8. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 8.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------|--|
| 9. Үе шатны | 9.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны |
|-------------|--|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

ажлын хуваарь	ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
	9.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
10. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	10.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
11. Алданги	11.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ	
12. Ажил дуусгах	12.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
13. Гэрээг цуцлах	13.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй. 13.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
14. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	14.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

**15. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

15.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 1.1	Барилгын угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх
ГЕН 2.1	Ажил эхлэх <i>2019он</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн 2019 он
ГЕН 3.1	Чанарын баталгаат хугацаа <i>3 жил</i> байна.
ГЕН 4.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,2%]</i> байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.

3 Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

4 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;

- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]